

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Нийтийн номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/178/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Т.Золоо

Утас: 70453799, Цахим хаяг: Zoloot@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,

Утас/факс: 7045-3317,

Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2026.02.06 № УВА - 2026/178/НА - СТА - ТМБ

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Увс аймгийн Нийтийн номын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Нийтийн номын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050057

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,624,034.86	20,908,942.64
33	АВЛАГА	9,230,374.86	6,930,992.64
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	9,230,374.86	1,795,344.64
335	Бусад авлага	00.00	5,135,648.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	5,135,648.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,393,660.00	13,977,950.00
354	Хангамжийн материал	18,393,660.00	13,977,950.00
35410	Бичиг хэргийн материал	539,450.00	535,750.00
35420	Аж ахуйн материал	17,354,210.00	12,942,200.00
35470	Бусад хангамжийн материал	500,000.00	500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,095,176,242.47	1,116,084,022.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,095,176,242.47	1,116,084,022.68
392	Биет хөрөнгө	1,048,676,242.47	1,069,584,022.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,067,303,232.00	1,066,985,417.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-221,091,233.08	-258,332,276.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,400,000.00	21,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,400,000.00	-21,400,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,985,239.00	61,667,680.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-40,577,512.25	-10,742,713.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,212,397.49	51,962,697.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,057,880.67	-19,176,527.70
39214	Бусад үндсэн хөрөнгө	125,000.00	125,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-111,110.42	-118,054.82
39217	Ном	172,888,110.40	177,212,800.40
393	Биет бус хөрөнгө	46,500,000.00	46,500,000.00
39301	Програм хангамж	4,768,780.00	4,768,780.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,768,780.00	-4,768,780.00
39303	Бусад биет бус хөрөнгө	46,500,000.00	46,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	1,122,800,277.33	1,136,992,965.32
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	44,587,244.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	44,587,244.80
413	Өглөг	00.00	44,587,244.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	5,536,436.03
4136	Бусад өглөг	00.00	39,050,808.77
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	35,136,935.77
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	3,913,873.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,122,800,277.33	1,092,405,720.52
51	Засгийн газрын хувь оролцоо	1,122,800,277.33	1,092,405,720.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	218,634,831.30	218,634,831.30
51101	Өмч: - төрийн	218,634,831.30	218,634,831.30
512	Хуримтлагдсан үр дүн	-126,176,947.70	-155,824,902.12
51210	Өмнөх үеийн үр дүн	-94,527,561.79	-93,780,959.40
51220	Тайлант үеийн үр дүн	-31,649,385.91	-62,043,942.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,030,342,393.73	1,029,595,791.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,122,800,277.33	1,136,992,965.32

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	579,543,882.44	603,688,920.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,107,000.00	45,100,672.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,107,000.00	45,100,672.00
120001	Хувьцааны ногдол ашиг	00.00	42,700,672.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,107,000.00	2,400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	2,400,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,107,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	571,436,882.44	558,588,248.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	462,033,382.44	436,876,348.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	462,033,382.44	429,740,700.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	7,135,648.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	109,403,500.00	121,711,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	109,403,500.00	121,711,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	611,193,268.35	634,083,476.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	611,193,268.35	634,083,476.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	575,822,341.08	627,315,947.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346,827,932.19	351,317,061.57
210101	Үндсэн цалин	249,224,894.44	256,168,433.56
210102	Нэмэгдэл	73,212,057.75	71,525,143.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,040,000.00	9,946,135.00
210104	Урамшуулал	13,350,980.00	13,677,350.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,335,841.29	45,104,571.84
210201	Тэтгэврийн даатгал	30,257,081.45	31,292,698.36
210202	Тэтгэмжийн даатгал	3,559,656.60	3,561,536.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,779,828.39	1,772,848.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,747,855.02	1,695,497.76
210205	Эрүүл мэндийн даатгал	6,991,419.83	6,781,990.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,950,959.29	143,639,185.77
210301	Гэрэл, цахилгаан	3,516,799.62	4,748,480.37
210302	Түлш, халаалт	91,767,289.67	134,089,190.40
210303	Цэвэр, бохир ус	4,666,870.00	4,801,515.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,234,890.00	12,012,147.00
210401	Бичиг хэрэг	3,405,300.00	1,832,420.00
210402	Тээвэр, шатахуун	3,818,780.00	994,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,020,670.00	1,887,317.00
210404	Ном, хэвлэл	704,700.00	397,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	472,500.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,812,940.00	1,143,500.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	5,756,310.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,633,000.00	8,922,800.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	133,000.00	350,000.00
210604	Урсгал засвар	5,500,000.00	8,572,800.00
2107	Томилолт, зочны зардал	2,656,000.00	1,860,000.00
210702	Дотоод албан томилолт	2,656,000.00	1,860,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,325,000.00	6,041,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,775,000.00	5,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	576,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	653,000.00	00.00
210807	Газрын төлбөр	465,000.00	465,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,858,718.31	58,419,181.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,618,100.00	11,186,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,240,618.31	47,232,881.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,370,927.27	6,767,528.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,146,800.00	490,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,362,000.00	490,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,784,800.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,224,127.27	6,277,528.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,224,127.27	6,277,528.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-31,649,385.91	-30,394,556.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-31,649,385.91	-30,394,556.81

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	572,436,882.44	561,169,648.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000,000.00	2,581,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	2,581,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	2,581,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	2,581,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	571,436,882.44	558,588,248.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	462,033,382.44	436,876,348.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	462,033,382.44	429,740,700.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	7,135,648.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	109,403,500.00	121,711,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	109,403,500.00	121,711,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	594,240,576.56	535,729,658.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	594,240,576.56	535,729,658.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	558,869,649.29	522,190,481.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	355,841,400.00	337,447,394.16
210101	Үндсэн цалин	221,860,255.52	219,318,789.87
210102	Нэмэгдэл	87,617,262.00	88,082,346.98

210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,300,000.00	14,979,655.89
210104	Урамшуулал	31,063,882.48	15,066,601.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,480,200.00	42,630,300.00
210201	Тэтгэврийн даатгал	30,246,600.00	28,818,426.52
210202	Тэтгэмжийн даатгал	3,558,400.00	3,561,536.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,779,200.00	1,772,848.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,779,200.00	1,695,497.76
210205	Эрүүл мэндийн даатгал	7,116,800.00	6,781,990.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,301,849.29	113,139,100.00
210301	Гэрэл, цахилгаан	3,516,799.62	4,764,980.37
210302	Түлш, халаалт	98,118,179.67	103,572,604.63
210303	Цэвэр, бохир ус	4,666,870.00	4,801,515.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,600,800.00	3,807,987.00
210401	Бичиг хэрэг	1,672,800.00	449,570.00
210402	Тээвэр, шатахуун	1,818,780.00	252,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,020,670.00	1,870,817.00
210404	Ном, хэвлэл	5,621,950.00	397,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	472,500.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,994,100.00	837,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,098,800.00	10,572,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,098,800.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	8,572,800.00
2107	Томилолт, зочны зардал	2,656,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	2,656,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,290,600.00	4,041,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,680,600.00	3,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	576,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,420,000.00	00.00
210807	Газрын төлбөр	758,000.00	465,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,600,000.00	9,051,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,600,000.00	9,051,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,370,927.27	13,539,176.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,146,800.00	2,126,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,362,000.00	1,726,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,784,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,224,127.27	11,413,176.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,224,127.27	11,413,176.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-21,803,694.12	25,439,990.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	25,439,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	25,439,990.00

2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	25,439,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	25,439,990.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-25,439,990.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-21,803,694.12	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,803,694.12	00.00

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,634,831.40	1,035,577,296.88	-61,501,074.60	00.00	1,192,711,053.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	301,233.15	00.00	301,233.15
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,634,831.40	1,035,577,296.88	-61,199,841.45	00.00	1,193,012,286.83
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,636,319.84	00.00	-11,636,319.84
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,634,831.30	1,030,342,393.73	-126,176,947.70	00.00	1,122,800,277.33
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	218,634,831.30	1,030,342,393.73	-126,176,947.70	00.00	1,122,800,277.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	746,602.39	00.00	746,602.39
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,634,831.30	1,030,342,393.73	-125,430,345.31	00.00	1,123,546,879.72
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-746,602.39	00.00	00.00	-746,602.39
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00

D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-30,394,556.81	00.00	-30,394,556.81
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,634,831.30	1,029,595,791.34	-155,824,902.12	00.00	1,092,405,720.52

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	434,140,700.00	428,044,571.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	434,140,700.00	428,044,571.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	432,014,700.00	425,918,571.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	341,042,700.00	337,447,394.16
210101	Үндсэн цалин	195,557,700.00	219,318,789.87
210102	Нэмэгдэл	106,039,700.00	88,082,346.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,553,000.00	14,979,655.89
210104	Урамшуулал	24,892,300.00	15,066,601.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,630,300.00	42,630,300.00
210201	Тэтгэврийн даатгал	29,050,000.00	28,818,426.52
210202	Тэтгэмжийн даатгал	3,395,100.00	3,561,536.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,697,500.00	1,772,848.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,697,500.00	1,695,497.76
210205	Эрүүл мэндийн даатгал	6,790,200.00	6,781,990.47
2104	Хангамж, бараа материалын зардал	5,650,200.00	5,645,377.00
210401	Бичиг хэрэг	900,000.00	449,570.00
210402	Тээвэр, шатахуун	450,000.00	252,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	1,870,817.00
210404	Ном, хэвлэл	2,500,200.00	2,235,190.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	900,000.00	837,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,602,600.00	25,602,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,102,600.00	22,102,600.00
210602	Тавилга	3,500,000.00	3,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,537,000.00	4,041,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	3,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	576,000.00
210807	Газрын төлбөр	937,000.00	465,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9051900.00	9051900.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,051,900.00	9,051,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2126000.00	2126000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,126,000.00	2,126,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,726,000.00	1,726,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	400,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	434,140,700.00	418,327,523.16
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	429,740,700.00	418,327,523.16
131001	Улсын төсвөөс санхүүжих	429,740,700.00	418,327,523.16
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,400,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,400,000.00	00.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	14.00	14.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		121,711,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		121,711,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		121,711,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		113,139,100.00
210301	Гэрэл, цахилгаан		4,764,980.37
210302	Түлш, халаалт		103,572,604.63
210303	Цэвэр, бохир ус		4,801,515.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,572,800.00
210604	Урсгал засвар		8,572,800.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Нийтийн номын сан нь Номын сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд ард түмэн оюуны мэдлэг олж авахад уламжлалт болон мэдээллийн технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ зөвхөн туслагч байх чиг үүрэгтэй байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Нийтийн номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Нийтийн номын сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,192.6 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	9,230.4	6,931.0	-2,299.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	18,393.7	13,977.9	-4,415.8
Үндсэн хөрөнгө	1,095,176.2	1,116,084.0	20,907.8
Нийт хөрөнгө	1,122,800.3	1,136,992.9	14,192.6
Өр төлбөр	0.0	44,587.2	44,587.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,122,800.3	1,092,405.7	-30,394.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,122,800.3	1,136,992.9	14,192.6

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 6,931.0 мянган төгрөг болж 2,299.6 мянган төгрөгөөр буурсан нь ажилчдаас авах авлага буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 13,977.9 мянган төгрөг болж 4,415.8 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал акталж устгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 1,116,084.0 мянган төгрөг болж 20,907.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 25,439.9 мянга, Соёлын яамнаас 3,794.9 мянга хандиваар 2,747.2 мянган төгрөгийн хөрөнгө ирсэн, тайлант онд 47,232.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцож, дахин үнэлгээгээр 67,701.0 мянган төгрөг хасагдсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,092,405.7 мянган төгрөг болж 30,394.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,290,700.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улсын төсвөөс зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 799,733.8 мянган төгрөгөөр бууруулж нийт зардлыг 490,966.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 434,140.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Гүйцэтгэлээр төсвөөс 429,876.4 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 9,400.0 мянга, нийт 439,276.4 төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагаанд 428,044.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702-Соёл урлаг 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	413,234.3	409,141.4	4,092.9	99%
2	80215- Эрдэм шинжилгээний ажил	5,000.0	3,000.0	2,000.0	60%
3	81855- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	11,506.5	11,503.2	3.3	99%
4	83603-дээд шатнаас хуваарилсан	9,535.6	4,400.0	5,135.6	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд тусгай зориулалтын шилжүүлэг 121,711.9 мянган төгрөгийн тогтмол зардлын санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, харин байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор багаж техник хэрэгслийн зардлаас 20,102.6 мянга, тавилга 3,500.0 мянга, ном 1,837.3 мянга, нийт 25,439.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Нийтийн номын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Золоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Нийтийн номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 611,193.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,111.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 634,083.5 мянган төгрөгийн 1 хувиар 6,340.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 5,072.6 мянган төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Нийтийн номын сангийн төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Байгууллагын даргын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/25 дугаар тушаалаар төсвийн хөрөнгөөр 500.0 мянган төгрөгийн бэлэг худалдан авсан байна. Дээрх зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамж		-	Байгууллагын үйл ажиллагаанд 4,768.7 мянган төгрөгийн программ хангамж ашиглаж байна.
2	Унаа, хоолны зардал	14,553.0	14,979.6	2025 онд албан хаагчдад хоолны зардлыг 14,553.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 14,979.6 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.
3	Сургалт, семинар		2,000.0	Увс аймгийн ЗДНХ-өөс орж ирсэн 2000.0 төгрөгөөр аймгийн Нийтийн номын санчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх тэдгээрт арга зүйн дэмжлэг үзүүлэх зохион байгуулсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ		-	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал		-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тоо	341,042.7	337,447.4	Увс аймгийн Нийтийн номын сангийн нь 2025 онд 11 орон тоотой үйл ажиллагаа явуулж 341,042.7 мянган төгрөгийн цалингийн зардал батлагдсанаас тайлант онд 337,447.4 мянган төгрөгийг ажилчдын цалин хөлс, урамшуулалд зарцуулсан байна.
7	Хэвлэл мэдээлэл	1,550.0	1,550.0	Орон нутгийн Сама, МВС телевиз өөрсдийн үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл бэлтгүүлсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 174, хугацаа хоцроож оруулсан 6, мэдээлэх хугацаа болоогүй 3 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Нийтийн номын сангийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар ажилчидтай холбоотой цалингийн өглөг, авлагыг анхаарах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 895.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 895.3 мянган төгрөгийн 395.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 500.0 мянган төгрөгийн албан шаардлага өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Илрүүлэлт

Цагийн балансаар нотлогдохгүй мөн томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 395.9 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс тооцож олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл цалин хөлс олгох журам"-ын 3.1-д Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь

Анхан шатны баримтаар нотлогдоогүй илүү цагийн нэмэгдэл 395.3 мянган төгрөгийг төлүүлэхээр акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт

Номын сангийн даргын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/25 дугаар тушаалаар төсвийн хөрөнгөөр 500.0 мянган төгрөгийн бэлэг худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дахь хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5 дах заалтад "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь

Төсвийн хөрөнгөөр 500.0 мянган төгрөгийн бэлэг худалдан авсан зөрчилд албан шаардлага өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
цагийн балансаар нотлогдохгүй мөн томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгэ эр илүү цагийн нэмэгдэл хөлс тооцож олгосон байна.	1	395.3	1	395.3								
төсвийн хөрөнгөөр 500,000 төгрөгийн бэлэг худалдан авсан байна.	1	500.0			1	500.0						
Дүн	2	839.3	2	395.3	1	500.0	0	0.0	0	0.0	0	0.0




Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЫ/
 АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН/
 БЭЛТГЭСЭН: АУДИТОР  Т.ЗОЛОО/

2026 оны 02 сарын 06-ны өдөр

